

„JOBka-д бүртгүүлж бас хонжвор хожоорой!“ уралдааны дүрэм

2025.3.7 – 2025.3.31

„JOBka-д бүртгүүлж бас хонжвор хожоорой!“ уралдааныг (цаашид зөвхөн **“Уралдаан”** гэх) энэхүү дүрмээр (цаашид зөвхөн **“Дүрэм”** гэх) зохицуулна.

1. Уралдааныг Зохион байгуулагч

- 1.1 Уралдааныг Зохион байгуулагч нь Foxconn European Manufacturing Services s.r.o. УБД: 25965361, хаяг: U Zámecku 27, Pardubičky, 530 03 Pardubice, Храдэц Краловэ хот дахь Мужийн шүүхэд хөтлөгддөг Бизнес үйл ажиллагааны бүртгэлийн дугаар C 17934 (цаашид зөвхөн **„Зохион байгуулагч”** гэх).
- 1.2 Уралдааныг JOBka аппликэшнээр (цаашид зөвхөн **„JOBka”** гэх) дамжуулан зохион байгуулна.

2. Хугацаа, байршил

- 2.1 Уралдаан **2025.3.7-ноос 2025.03.31 хүртэл болно** (цаашид зөвхөн „Уралдааны хугацаа” гэх).
- 2.2 Уралдаан БНЧУ-ын нутаг дэвсгэрт JOBka аппликэшнээр дамжин зохиогдоно.

3. Уралдааны Нөхцөлүүд

- 3.1 Уралдаанд зөвхөн 15-аас дээш насны, Чех улсад оршин суух хаягтай, **Фоксконн группын ажилтан** (дүрмийн 8.1 –ийг үз) бөгөөд энэхүү Дүрмийн бүх нөхцөлийг биелүүлэх хүн оролцоно (цаашид зөвхөн **„Уралдаанд оролцогчид”** гэх).
- 3.2 **Уралдаанд оролцогч бүр Уралдаанд хэд хэдэн удаа оролцож болно**, ө.х. Уралдаанд хамрагдаж буй төрөлд олон удаа оролцож болно (Дүрмийн 4.2 үз).
- 3.3 Уралдаанд сайн дураар оролцоно. Оролцогч уг Уралдаанд оролцож буй бол энэхүү Дүрмийг зөвшөөрч, мөрдөх ёстой. Уралдаанд оролцогч мөн JOBka аппликэйшний бүхий л нөхцөлийг, ялангуяа түүнийг ашиглах болох ёсзүйг баримтлах дүрмийг чанд мөрдөнө.
- 3.4 Уралдаанд оролцох нөхцөл нь бараа үйлчилгээ худалдан авах, худалдах тухай биш юм.

4. Уралдааны зарчим

- 4.1 Soutěžící se zapojí do Soutěže následovně:

Уралдаанд оролцогчид Уралдаанд оролцохдоо Уралдааны хугацаанд (2.1-р зүйл) JOBka аппликэйшныг өөрийн гар утсанд татаж, хувийн ID болон myFOX хүний нөөцийн системд байгаа тусгай QR код ашиглан амжилттай бүртгүүлж, уралдааны хугацаанд зохион байгуулагчийн нийтэлсэн асуулгуудаас доод тал нь нэгэнд нь хариу өгч идэвхтэй оролцох ёстой (Уралдаанд оролцогч эдгээр бүх нөхцлийг биелүүлсэн байх шаардлагатай). (Цаашид зөвхөн **“Уралдааны хариулт”** гэх).

- 4.2 Хэрвээ Оролцогч Уралдааны хугацаанд зохион байгуулагчийн нийтэлсэн олон асуулгад хариулбал, тухайн асуулгад бичсэн хариулт тус бүр нэг уралдаанд оролцолт гэж тооцогдоно. Иймд, бүх Оролцогч Уралдаанд дээд тал нь дөрвөн (4) удаа оролцож болно.
- 4.3 **Уралдаанд оролцож буй хариултын агуулгыг зөвхөн Уралдаанд оролцогч хариуцах** бөгөөд дараах нөхцлүүдийг дагаж мөрдөх үүрэгтэй:

- a) Уралдаанд оролцох хариулт нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, эрх зүйн актуудад харшлах ёсгүй;
- b) Уралдааны хариулт нь Оролцогч эсвэл Зохион байгуулагчийн ашиглах, боловсруулах эрхгүй хувийн мэдээлэл, бичлэг, хөрөг зургийг агуулах ёсгүй;
- c) Уралдааны хариулт нь ёс суртахууны хэм хэмжээ, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ёс журамд харшлах, хүний нэр төрийг гутаах, доромжлох (ялангуяа порно, хүчирхийлэл, садар самуун, үндэстэн, угсаатан, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах, гэмт хэргийн үйлдлийг өөгшүүлэх эсвэл хууль бүс үйлдэлд уриалах гэх мэт) аливаа илэрхийллүүдийг агуулж болохгүй);
- d) Уралдааны хариулт нь гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх (ялангуяа зохиогчийн эрх, худалдааны тэмдэг, гарал үүслийн заалт зэрэг) зөрчих ёсгүй;
- e) Уралдааны хариулт нь далд сурталчилгаа агуулж болохгүй;
- f) Уралдааны хариулт нь ямар нэг байдлаар Зохион байгуулагч болон бусад этгээдийн нэр хүндэд халдах ёсгүй.

4.4 Зохион байгуулагч нь эдгээр Дүрэмд заасан шаардлагыг хангаагүй **Уралдааны хариултыг** уралдаанд оруулахгүй байх, эсвэл ямар нэгэн шалтгаан тайлбарлахгүйгээр уралдаанаас ямар ч үед хасах эрхтэй бөгөөд үүний төлөө ямарваа нөхөн төлбөр олгохгүй. Гэхдээ Зохион байгуулагч нь эдгээр Дүрмийг тогтмол хянах үүрэг хүлээхгүй бөгөөд Оролцогч зөрчил гаргасанд хариуцлага хүлээхгүй.

4.5 Зохион байгуулагч нь техникийн асуудал, ялангуяа **JOBka** аппликейшны үйл ажиллагаанд саатал гарахад хариуцлага хүлээхгүй.

5. Уралдааны шагнал, ялагчийг шалгаруулах арга

5.1 Уралдааны шагнал нь дараах зүйлс байна:

- a) Alza.cz-гээс 5000 кроны бараа худалдан авах эрхийн бичиг 3 ш;
- b) Alza.cz-гээс 3000 кроны бараа худалдан авах эрхийн бичиг 3 ш;
- c) Alza.cz-гээс 1000 кроны бараа худалдан авах эрхийн бичиг 3 ш;
- d) JOBka логотой спорт ундааны сав 30 ш;
- e) JOBka логотой керамик аяга 30 ш.

5.2 Зохион байгуулагчийн зохион байгуулах хаалттай сугалаагаар Ялагчийг тодруулах бөгөөд тохиолдлоор сугалах байдлаар шагналын нийт тоотой (5.1-р зүйл) адил тооны ялагчдыг сонгоно. Нэг оролцогч нэг л шагнал хожих боломжтой.

6. Уралдааны дүнг танилцуулах, шанал гардуулах

6.1 Уралдааны ялагчаар тодорсон **Оролцогч** (цаашид "Ялагч" гэх) нь өөрийн хожлын талаар Зохион байгуулагчаас 2025 оны 4-р сарын 21-ний дотор и-мэйл, эсвэл утсаар, текст мессеж зэрэг JOBka аппликейшнд бүртгүүлсэн холбоо барих мэдээллээр дамжуулан мэдэгдэнэ.

6.2 Шагналаа авах сонирхолтой Ялагч нь Зохион байгуулагч холбогдсон өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор шагналаа авах талаар тохиролцох ёстой. Шагналыг харилцан тохиролцсоны үндсэн дээр Пардубице дахь Foxconn компанид эсвэл Кутна Хора дахь Foxconn компанид биечлэн авах боломжтой. Зохион байгуулагч нь Ялагчид шагналаа авах боломжит хугацааг санал болгоно.

6.3 Хэрэв Ялагч нь эдгээр Дүрмийн 6.2-р зүйлд заасан хугацаанд Зохион байгуулагчтай шагналаа авах талаар тохиролцоогүй, эсвэл тохирсон хугацаанд шагналаа аваагүй тохиолдолд, түүний шагнал авах эрх хүчингүй болж, шагнал нь Зохион байгуулагчийн мэдэлд шилжинэ.

6.4 Уралдааны шагналууд бэлэглэлтийн хэлбэрээр олгогдох бөгөөд Зохион байгуулагч чанарын баталгаа өгөхгүй, аливаа доголдолд хариуцлага хүлээхгүй.

6.5 Зохион байгуулагч Ялагчийн гэрэл зургийг авч хадгалан, цаашид нийтлэхийг зөвшөөрч байна. Энэхүү гэрэл зургууд нь Зохион байгуулагчийн байгууллагын дотоод хэрэглээнд, интернет сайт болон Facebook, Instagram, LinkedIn, X, YouTube зэрэг сошиал сүлжээнд нийтлэгдэх боломжтой. Гэрэл зураг

авах нь үнэ төлбөргүй бөгөөд шагнал гардуулах нөхцөлд хамаарахгүй. Ялагч өөрийн зураг авахуулахаас татгалзах эрхтэй.

- 6.6 Ялагчид хожлын талаарх мэдэгдэл болон тухайн шагнал нь хүргэгдэхгүй байх, алдагдах, гэмтэх, устгах, хүргэгдэхгүй зэргээр Оролцогч, хүргэлтийн үйлчилгээ үзүүлэгч эсвэл цахим харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэгчийн бүрүүгаас шалтгаалсан тохиолдолд Зохион байгуулагч хариуцлага хүлээхгүй.
- 6.7 Шагналыг шүүхийн журмаар шаардах боломжгүй. Оролцогч нь Зохион байгуулагчаас тогтоосон шагналаас өөр шагнал нэхэх эрхгүй. Шагналыг бэлэн мөнгөөр олгох эсвэл өөр хэлбэрээр солих боломжгүй.
- 6.8 Тухайн Ялагчийн шагнал хожсон сарын албан татвар ногдох орлогод шагнал нь хамрагдана гэдгийг Оролцогч ойлгож байна.

7. Хувийн мэдээлэл боловсруулалт

- 7.1 Зорилго ба боловсруулах хүрээ. Оролцогч нь уралдаанд оролцсоноор Зохион байгуулагчид өгсөн хувийн мэдээлэл нь энэхүү Дүрэмд заасны дагуу уралдааны зохион байгуулалт, шалгаруулалт (сугалаагаар шалгаруулах мөн орно), Ялагчтай холбогдох зорилгоор хэрэглэгдэхийг хүлээн зөвшөөрнө. Уралдаан тухайн сошиал сүлжээнд явагдаж байгаа тохиолдолд оролцогчийн нэр, овог болон/эсвэл түүний сошиал сүлжээнд хэрэглэдэг нэр нийтлэгдэхийг зөвшөөрнө. Зохион байгуулагч нь эдгээр мэдээллийг хянагч байдлаар боловсруулж, нэр, овог болон/эсвэл сошиал сүлжээн дэх хэрэглэгчийн нэрийг өөрийн байгууллагын хүрээнд, албан ёсны вэбсайт болон Facebook, Instagram, LinkedIn, X, YouTube зэрэг сошиал сүлжээнүүдэд нийтлэх боломжтой. Хэрэв оролцсон бүтээлд гэрэл зураг багтсан бол Зохион байгуулагч нь уг зургийг (оролцогчийн дүр төрхийг) мөн боловсруулж, нийтлэхийг Оролцогч хүлээн зөвшөөрнө. Энэхүү мэдээллийн боловсруулалт нь уралдааны хэрэгжилтэд зайлшгүй шаардлагатай болно. Ялагчийн зураг, нэр, овог болон/эсвэл сошиал сүлжээн дэх хэрэглэгчийн нэр нь сурталчилгааны зорилгоор болон дотоод статистик зорилгоор ашиглагдана.
- 7.2 Боловсруулах хугацаа. Зохион байгуулагч нь Оролцогчид болон Ялагчдын хувийн мэдээллийг зөвхөн зайлшгүй шаардлагатай хугацаанд, тухайлбал, уралдааны хугацаанд (2.1-р зүйл) болон уралдааны нөхцөлийг хянах, шагнал гардуулах зорилгоор 3 сарын хугацаанд боловсруулна. Уралдаан дууссанаас хойш 5 жилийн хугацаанд зохион байгуулагч нь оролцогчдын нэр, овог болон/эсвэл нийгмийн сүлжээн дэх хэрэглэгчийн нэрийг дотоод статистикийн зорилгоор хадгалах болно. Уралдааны бүтээл, зураг, ялагчийн нэр, овгийг зохион байгуулагч нийтэлж болох бөгөөд энэ нь зохион байгуулагч устгах хүртэл хэвээр үлдэнэ (Оролцогчид хүссэн үедээ мэдээлэл устгахыг хүсэх эрхтэй). Ялагчдын мэдээлэл (нэр, овог болон/эсвэл нийгмийн сүлжээн дэх хэрэглэгчийн нэр) нь Foxconn группийн компаниудын хүрээнд, компанийн "Živý Foxconn" сэтгүүл, вэбсайт, нийгмийн сүлжээ (Facebook, Instagram, LinkedIn, X, YouTube, TikTok) зэрэг нийтлэг харилцааны хэрэгслээр нийтлэгдэх боломжтой бөгөөд энэ нь зохион байгуулагч устгах хүртэл хадгалагдана (Оролцогчид мэдээлэл устгахыг Зохион байгуулагчаас хэдийд ч хүсэх эрхтэй).
- 7.3 Аюулгүй байдал, дүрмийн зохицуулалт. Зохион байгуулагч нь эдгээр Нөхцлийн дагуу хувийн мэдээллийг боловсруулахдаа хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг, ялангуяа Европын Парламент болон Зөвлөлийн (ЕХ) 2016/679 тоот журам ("GDPR") болон Хувийн мэдээлэл боловсруулах тухай 110/2019 тоот хуульд нийцүүлэн дагаж мөрдөх үүрэг хүлээнэ. Түүнчлэн, хувийн мэдээлэлд зөвшөөрөлгүй болон санамсаргүй хандалт, өөрчлөлт, устгал, алдагдал, зөвшөөрөлгүй дамжуулалт, боловсруулах болон бусад зүй бус ашиглалтаас сэргийлэх шаардлагатай арга хэмжээг авна.
- 7.4 Зохион байгуулагч нь Оролцогчийн хувийн мэдээллийг шууд маркетинг эсвэл профайл бүрдүүлэх зорилгоор боловсруулахгүй бөгөөд хувийн мэдээллийг гуравдагч улс руу шилжүүлэхгүй.
- 7.5 Оролцогчийн эдлэх эрх. Уралдаанд оролцогч бүр хувийн мэдээллээ хамгаалах үүднээс зохих хууль журмын дагуу ялангуяа дараах эрхүүдийг эдлэнэ:

- a) Хувийн мэдээлэлдээ нэвтрэх эрх – түүнийг боловсруулж буй арга явцтай танилцах, хувийн мэдээлэл хүлээж авагсад, хадгалах хугацаа, эх үүсвэр зэргийн талаарх мэдээллийг авах эрхтэй;
- b) Бүрүү мэдээллээ засаж залруулахыг хүсэх эрхтэй;
- c) хувийн мэдээллээ устгуулах эрхтэй;
- d) хувийн мэдээллийн боловсруулалтыг хязгаарлах эрхтэй, хувийн мэдээлэл бүрүү байвал, боловсруулалт нь эрх зөрчсөн байвал уг хувийн мэдээллийг устгуулахгүй, харин түүний ашиглалтыг хязгаарлах, Хувийн мэдээллүүдийг боловсруулах хэрэггүй болсон ч та хууль ёсны эрхийнхээ дагуу өмгөөлөлт, тодорхойлолт, тодорхой үйлдэлд хэрэглэхийг хүсэх;
- e) хувийн мэдээллээ боловсруулахыг эсэргүүцэх эрх;
- f) хувийн мэдээлэл нь гэрээ зөвшөөрлийн үндсэн дээр бүтэцжсэн, түгээмэл хэрэглэгддэг төхөөрөмж дээр цахим хэлбэрээр боловсруулагдсан бол автомат аргаар дамжуулж хүлээж авахыг хүсэх эрхтэй;
- g) Хувийн мэдээлэлтэй харьцах зөвшөөрлөө цуцлах эрх; Гэхдээ зөвшөөрлөө цуцлахаас тань өмнө хийгдсэн хувийн мэдээллийн боловсруулалт үүнд хамаарахгүй;
- h) Хувийн мэдээллийг хамгаалах албанд гомдол гаргах эрхтэй (хаяг: Úřad pro ochranu osobních údajů, se sídlem Pplk. Sochora 727/27, 170 00 Praha 7 – Holešovice).

Уралдаанд оролцогч бүр хувийн мэдээллээ өгөхгүй байх эрхтэй. Хэрвээ ийм шийдвэр гаргавал, Уралдаан зохион байгуулахад оролцогч бүрийн хувийн мэдээлэл шаардлагатай тул мэдээллээ өгөхөөс татгалзсан оролцогч Уралдаанд оролцох боломжгүй болно. Хэрэв хувийн мэдээллийн боловсруулалт нь зохих хууль журмын дагуу хийгдэх бол түүний үр дагавар мөн хуулийн дагуу зохицуулагдах болно.

Зохион байгуулагч нь энэхүү уралдаантай холбоотойгоор хувийн мэдээллийг автомат болон шаардлагатай тохиолдолд гар аргаар боловсруулна. Автомат шийдвэр гаргалт (зөвхөн автомат мэдээлэл боловсруулахад үндэслэсэн шийдвэр) болон профайл бүрдүүлэлт хийгдэхгүй.

- 7.6 Зохион байгуулагчтай холбогдох хаяг, гомдол санал. Хувийн мэдээлэлтэй харьцаж буйтай холбоотой Зохион байгуулагчийн үйл ажиллаганы талаарх гомдлыг компанийн Compliance хэлтэст ирж өгөх, эсвэл дараах хаягаар имэйл бичиж болно: GDPRInfo@emea.foxconn.com. Оролцогчид уг хаягаар дамжуулан Зохион байгуулагчид эсэргүүцэл, хүсэлт, гомдол болон бусад асуултаа гаргах боломжтой. Чех Улсад хувийн мэдээллийн хамгаалалтын хяналтын байгууллага нь **Хувийн мэдээлэл хамгаалах газар** (Úřad pro ochranu osobních údajů) юм.

- 7.7 Зохион байгуулагч нь нийгмийн сүлжээ үйлчилгээ үзүүлэгчийн мэдээлэл боловсруулах үйл ажиллагаанд хариуцлага хүлээхгүй бөгөөд уг боловсруулалт нь тухайн үйлчилгээ үзүүлэгчийн нөхцлөөр зохицуулагдана (www.instagram.com, www.facebook.com г.м.).

8. Төгсгөл

- 8.1 Фоксконн группын дараах компаниуд энэхүү Дүрмийг баримтлана:
- a) Foxconn European Manufacturing Services s.r.o., хаяг: U Zámečku 27, Pardubičky, 530 03 Pardubice, УБД: 25965361,
 - b) Foxconn Technology CZ s.r.o., хаяг: Karlov 245, 284 01 Kutná Hora, УБД: 27516032,
 - c) FOXCONN CZ s.r.o., хаяг: U Zámečku 27, Pardubičky, 530 03 Pardubice, УБД: 25938002,
 - d) GLOBAL SERVICES SOLUTIONS s.r.o., хаяг: U Zámečku 27, Pardubičky, 530 03 Pardubice, УБД: 27524850.
 - e) SafeDX s.r.o., хаяг: K Žižkovu 813/2, Vysočany, 190 00 Praha 9, УБД: 04585119,
 - f) Foxteq CZ s.r.o., хаяг: U Zámečku 27, Pardubičky, 530 03 Pardubice, УБД: 17405459.
- 8.2 Уралдааны хүрээнд энэхүү Дүрэм цорын ганц бөгөөд бүрнээрээ тооцогдоно. Хэрэв энэ Дүрмийн тодорхой хэсэг эсвэл холбоос линк нь нийтлэгдсэн бол энэ Дүрэм бүрэн эхээрээ хүчинтэй үйлчилнэ.

- 8.3 Энэхүү Дүрэм нь myfoxconn.cz вэбсайт дээр цахим хэлбэрээр нийтлэгдсэн бөгөөд мөн Зохион байгуулагчийн албан ёсны хаягт байршилд (1.1-р зүйлд заасан) Уралдааны хугацаа дуусах хүртэл бичгээр хадгалагдана.
- 8.4 Зохион байгуулагч нь Уралдааны зохион байгуулалт болон явцтай холбоотой бүх асуудлаар эцсийн шийдвэр гаргах эрхтэй. Үүнд уралдааны түр зогсолт, хойшлуулалт, цуцлалт, хугацаанаас өмнө дуусгах, эсвэл эдгээр Дүрэмд өөрчлөлт оруулах зэрэг үйл ажиллагаа багтана. Зохион байгуулагч нь уралдааны явцад эдгээр Дүрмийг өөрчлөх, тухайлбал, Ялагч тодруулах арга, шагналын төрөл, тоо хэмжээг өөрчлөх, мөн онцгой нөхцөлд уралдааныг бүрэн цуцлах эрхтэй. Мөн Зохион байгуулагч нь уралдаанд хөндлөнгөөс оролцох, дүрэм зөрчих оролдлого байж болзошгүй гэж үзвэл оролцогчийг шагнал авах эрхгүйд тооцох, уралдаанаас хасах бүрэн эрхтэй бөгөөд энэ тохиолдолд оролцогч аливаа нөхөн төлбөр шаардах эрхгүй. Маргаан гарах тохиолдолд Зохион байгуулагчийн шийдвэр эцсийнх байх болно.